



Монгол Улс эдийн засгийн өсөлтөд ач холбогдолтой 30 гаруй ашигт малтмалыг тодорхойлсон байдаг. Эдгээрээс алтны үндсэн орд, хайлуур жонш, төмөр, шороон орд, газрын тос, давс, элс-хайрга, карбонат, хөнгөнцагаан, лити, бал чулуу, газрын ховор элемент гэсэн 12 төрлийн ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг АМЕП 2 хөтөлбөр боловсрууллаа. Дэлхийд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт татахыг зорьж буй Монгол Улсын хувьд олон улсын стандартад нийцсэн аргачилсан зөвлөмжтэй болж буй нь нэн чухал юм. Манай мэдээллийн хуудсын энэ дугаараас та бүхэн АМЕП 2 хөтөлбөр Монгол дахь геологийн судалгаа, шинжилгээ, эрэл хайгуулын тайлан бичих, хүлээн авах үйл явцыг стандартчилахад хэрхэн хувь нэмрээ оруулж байгаа талаар уншаарай. УУХҮЯ аргачилсан зөвлөмж боловсруулж, хэрэглэж эхэлснээс хойш ашигт малтмалын нөөц тогтоох, бүртгэх үйл явц ил тод, ойлгомжтой болсон зэрэг ахиц дэвшил гарч байна гэжээ. Та бүхэн [энд дарж](#), аргачилсан зөвлөмжүүдийг англи, монгол хэл дээр татаж авах боломжтой.



А.Дэлгэрсайхан: Нэгдсэн стандарттай болсноор хөрөнгө оруулалт татах боломжтой

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын Геологийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга А.Дэлгэрсайхантай АМЕП 2 хөтөлбөр ярилцлаа.

- **Аргачилсан зөвлөмж гэдгийг энгийнээр тайлбарлаж өгнө үү.**

- Цөөн үгээр хэлбэл ашигт малтмалын ордын нөөцийн тооцооны тайланг бэлтгэж, улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, нөөцийн хөдөлгөөн хийлгэхийн тулд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг аж ахуйн нэгж, геологичид, уурхайчдад тусалцаа үзүүлэхэд үндсэндээ чиглэгдсэн. Тийм ч учраас геологийн салбарын мэргэшсэн, зөвлөх мэргэжилтэнд гарын авлага, зайлшгүй мэдэж байх учиртай материалын нэг юм.

- **АМЕП 2 хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулсан ашигт малтмалыг сонгох болсон шалтгаан юу вэ?**

- Монгол орны геологийн судалгаа, уул уурхайн үйлдвэрлэл, эдийн засагт чухал суурийг эзэлж байгаа голлох ашигт малтмал болон цаашид хэтийн төлөвтэй байж болох өндөр технологийн түүхий эд, элемент, түгээмэл тархацтай зэрэг

30 гаруй ашигт малтмалын аргачилсан зөвлөмж боловсруулахаар төлөвлөгдсөн. Энэ хүрээнд технологийн хөгжилд нэн шаардлагатай газрын ховор элемент, энерги хадгалахад зориулагддаг баттареин лити, бал чулуу, мөн барууны улс оронд “аж үйлдвэрлэлийн ашигт малтмал” гэгддэг элс-хайрга, карбонат, хөнгөнцагаан зэргийг сонгон Аргачилсан зөвлөмж боловсруулсан.

- **Эдгээр зөвлөмж одоо хэрхэн ашиглагдаж байна вэ?**

- Ашигт малтмалын төрөл бүрээр хайгуул хийж ордын нөөц тогтоох, тайлагнах нэгдсэн стандарт, заавар, зөвлөмжтэй болж түүнийг мөрдлөг болгосноор хайгуулын ажлын үе шат, ашигт малтмалын нөөцийн зэргийн нарийвчлал, нөөц тогтоох, бүртгэх үйл явцыг ойлгомжтой, үр дүнтэй болгож, маргаантай асуудлыг шийдвэрлэснээр хайгуулын ажлын чанар болон иж бүрэн байдал нь хөрөнгө оруулалт татах, хайгуул хийгдсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад түлхэц болно гэж найдаж байна.

А.Дэлгэрсайхантай хийсэн ярилцлагыг [энд дарж](#) уншаарай.

Төвлөрөл: Австрали, Чили, БНХАУ

Нөөц - 2 сая 803 мянган тонн



Цахилгаан
машин



Зөврийн
компьютер



Ухаалаг
утас



Сэтгэцийн
эрүүл мэнд



Зүрхний
аппарат

Лити



АШИГТ МАЛТМАЛУУДЫГ ЮУНД ХЭРЭГЛЭДЭГ ВЭ?

Бал чулуу

Төвлөрөл: БНХАУ, Бразил, Канад

Нөөц - 7 сая 140 мянган тонн



Цөмийн
реактор




Цэнэг



Зэвсэгт
хүчин



Ган
хайлуулагч





Карбон
мяндас



Газрын ховор элемент

Төвлөрөл: БНХАУ, Австрали, АНУ

Нөөц - 3 сая 270 мянган тонн



Зурагтын
дэлгэц



Зөврийн
хард диск



Салхин
сэнс



Дуран



Ниобиум



Сансар
судлал



Соронзон
бичлэг



Хийн
хоолой



Зуух



Цөмийн
реактор

Төвлөрөл: Бразил, Канад, бусад

Нөөц - 216 мянган тонн

Эх сурвалж: Австралийн уул уурхайн зөвлөл

АВСТРАЛИ, МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗАР 2021-2022 ОНД АМЕП 2 ХӨТӨЛБӨРИЙН ХИЙХ АЖЛЫГ БАТАЛЛАА

Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам болон Монгол Улсын Сангийн яам АМЕП 2 хөтөлбөрөөс 2021-2022 онд хэрэгжүүлэх төсөл, үйл ажиллагааг баталлаа. Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, эрдэс баялгийн салбарын аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх арван төслийг танилцуулъя.

1. “Ашигт малтмалын тухай” хуулийн шинэчилсэн найруулга төслийн хэлэлцүүлэг. Хамтрагч: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)
АМЕП 2 хөтөлбөр УУХҮЯ-ыг ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогду олон нийтийн хэлэлцүүлэг явуулахад техникийн тусламж үзүүлнэ. Үүнд, хуулийн шинэчилсэн найруулгыг олон нийтэд ойлгомжтой байдлаар боловсруулах, хуулийн шинэчилсэн найруулгыг англи хэл рүү орчуулах, УБ хот болон сонгосон аймгуудад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн санал, зөвлөмжийг нэгтгэн, хуулийн шинэчлэлийг бэлтгэхэд нь УУХҮЯ-нд туслах ажлууд багтаж байна.

2. Үндэсний геологийн албаны гео-мэдээллийн санд хувийн хөрөнгөөр хийгдсэн геологи-хайгуулын ажлын тайлангийн мэдээллийг нэгтгэх нь. Хамтрагч: Үндэсний геологийн алба (ҮГА)
АМЕП 2 хөтөлбөр геологичдын багтай хамтран, хувийн хөрөнгөөр хийсэн геологи-хайгуулын ажлын

тайланг судалж, үндэсний геологийн гео-мэдээллийн сан (ҮГМС), геологийн каталогийн МонГеоКат системд оруулахад бэлтгэнэ. АМЕП 2 хөтөлбөр хуульчтай хамтран, хувийн хөрөнгөөр хийсэн геологи-хайгуулын ажлын мэдээллийн нууцлалтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг судалж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс гео-мэдээлэлд нэвтрэх зөвшөөрөл авахад нь ҮГА-нд дэмжлэг үзүүлнэ. ҮГМС-г хувийн хөрөнгөөр хийсэн геологи-хайгуулынажлын мэдээллээр баяжуулснаар хайгуулын ажлын эрсдлийг багасгаж, хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлдэг.

3. Чулуун сангийн мэдээллийн өгөгдөл боловсруулах, чанар сайжруулах нь. Хамтрагч: Үндэсний геологийн алба (ҮГА)
Чулуун сангийн дээж тус бүр, тэр дундаа, газрын ховор элементийн төрлийн чулууны геохими, гео цаг хугацаа, геофизик, чулуужилтын анализ мэдээллийг шинэчилж, гео-мэдээллийн сан, ҮГМС, МонГеоКат систем рүү оруулна. ҮГА чулуужсан шинжилгээг өндөр нарийвчлалтай хийдэг шинэ тоног төхөөрөмж худалдан авахад нь АМЕП 2 хөтөлбөр тусална.

Үргэлжлэл дараагийн хуудсанд >>



АМЕП-ийн 2021-2022 оны ажлууд (Үргэлж.)

4. “Ашигт малтмалын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой журам боловсруулах. Хамтрагч: УУХҮЯ



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Холбогдох дүрэм журмыг сайн бичиж, бэлтгэсэн байх нь ашигт малтмалын хуулийн шинэчлэлийг үр дүнтэй, уялдаа холбоо

бүхий, ил тод хэрэгжүүлэхэд чухал түлхэц үзүүлнэ. АМЕП 2 хөтөлбөр УУХҮЯ, мэргэжлийн холбоо, уул уурхайн компани, зөвлөх, иргэний нийгмийн төлөөллүүдтэй хамтран, уурхайн үйл ажиллагааны онцлог шатлал бүртэй холбоотой дүрэм журам боловсруулна. Үүнд, геологийн судалгаа, хайгуул, тусгай зөвшөөрөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, уурхайн төлөвлөлт, нөхөн сэргээлт, хаалттай холбоотой дүрэм журам багтана. Дүрэм журмаар захиргаа, шийдвэр гаргалт, хэрэгжүүлэлтийн үе шатуудыг зохицуулдаг бол удирдамж нь мэргэжилтэн, уул уурхайн компаниудын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд тусалдаг баримт юм.

5. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээн (БОННУ) дэх олон нийтийн оролцоо. Хамтрагч: Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)



БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

2020-2021 онд АМЕП 2 хөтөлбөр БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлсэн ажлаа үргэлжлүүлэн, БОННУ дэх олон нийтийн

оролцоог хангах ажлаа орон нутгийн мэргэжилтнүүдэд гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор удирдамж боловсруулна. Орон нутгийн мэргэжилтэн, иргэдийг олон нийтийн оролцооны тэргүүн туршлагаудыг харуулсан цахим сургалтад хамруулна. БОННУ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн тайлан зэргийг бүртгэдэг одоогийн системийг үнэлж, эдгээрийг нэгтгэсэн, олон нийтэд илүү нээлттэй загварчлал гаргана. Ингэснээр БОАЖЯ нь БОННУ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цахимаар үнэлэх, хэрэгжилтийг нь хангуулах боломж нээгдэнэ.

6. Газрын хэвлийн тухай хуулийг шинэчлэхтэй холбоотой мэдээлэл, зөвлөмжөөр хангах нь. Хамтрагч: УУХҮЯ, ажлын хэсэг

Геологи, уул уурхай, газрын тос, газрын хэвлийтэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулдаг хуулиудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор газрын хэвлийн хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэг УУХҮЯ-н дээр байгуулагдлаа. АМЕП 2 хөтөлбөр хуулийн үзэл баримтлал боловсруулах, үр нөлөөллийн үнэлгээ хийх зэргээр тус ажлын хэсгийг дэмжинэ. Ажлын хэсгийн үйл ажиллагаа мөн Үндэсний геологийн албаны эрх, үүргийг хуулийн хүрээнд тодорхойлоход нөлөөлөх магадлалтай.

7. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний удирдамж боловсруулах, сургалт зохион байгуулах. Хамтрагч: МОНВАЛ Хороо (Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн зөвлөл)

Хөрөнгийн үнэлгээний тухай хууль 2021 оны УИХ-ын чуулганд өргөн баригдаж байна. Тус хуулиар ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ нь тусгай, онцлог ажил мэргэжил

гэдгийг зааж өгчээ. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хүрээнд Монголын үнэлгээчид ашигт малтмалын хөрөнгө үнэлэхдээ удирдамж болгох бичиг баримт боловсруулах олон улсын мэргэжилтнүүдийг АМЕП 2 урьж ажиллуулна. МОНВАЛ хороо Австралийн уул уурхайн мэргэжилтнүүдийн хамгийн том байгууллага болох AusIMM-тэй хамтран, үнэлгээчид, мэргэжилтнүүдэд үнэлгээний арга зүй, МОНВАЛ кодексийн сургалт явуулахад нь АМЕП 2 хөтөлбөр тусална.

8. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж. Хамтрагч: УУХҮЯ

УУХҮЯ-тай байгуулсан түншлэл, геологи-хайгуулын ажил явуулах, нөөцийн тооцоо бүхий үр дүнгийн тайланг боловсруулах нэгдсэн стандарттай болох зорилтын хүрээнд АМЕП 2 хөтөлбөр ШУТИС-ийн Эрдэс баялаг, геомэдээллийн сургалтын төвд захиалан, кобальт-никел, манганиз, берилиум, хром, фосфат гэсэн таван төрлийн ашигт малтмал эрж хайх, тайлагна аргачилсан зөвлөмж боловсруулна. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх нэгдсэн стандарт бүхий аргачилсан зөвлөмжтэй болж, өргөн хүрээнд хэрэглэснээр ашигт малтмал, түүний нөөцийн бүртгэлийг илүү үр дүнтэй, ил тод, тодорхой хийх боломж бүрддэг.

9. Эрдэс баялгийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх цахим сургалт. Хамтрагч: “Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо” ТББ, УУХҮЯ

УУХҮЯ 2019 оноос эхлэн, геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус бодлогыг уул уурхайн компаниуд үйл ажиллагаандаа тусгахад нь АМЕП 2-ын төсөл дэмжлэг үзүүлэх зорилготой. Канадын Засгийн газрын санхүүжилттэй СЕСМИМ төслийн хүрээнд цуврал гарын авлага бэлтгэн гаргасныг цахим сургалтын хэлбэрт оруулна. Ингэснээр сургалтын материалыг уян хатан байдлаар илүү олон хүнд хүргэх боломж бүрдэнэ. Австралийн ажиллах хүчний жендерийн тэгш эрхийн агентлаг, Австралийн уул уурхайн салбар дахь жендерийн тэгш байдлын санаачлагаас мөн шаардлагатай сургалтын агуулгыг нэгтгэх боломжийг АМЕП 2 хөтөлбөр судална.



10. Нүүрсний давхаргын метан хийн гео-мэдээллийг сайжруулах нь. Хамтрагч: Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)



Монгол Улс нүүрсний орд, нөөц, олборлолтын талаар арвин туршлага, түүхтэй боловч нүүрсний давхаргын метан хийн геомэдээлэл хомс, хөрөнгө оруулагчдыг татах баримт материал ховор байна. Тиймээс АМЕП 2 хөтөлбөрийн хүрээнд одоо байгаа нүүрсний давхаргын метан хийн геомэдээллийг нягтлан үзэж, хөрөнгө оруулагчдад зориулсан хайгуулын мэдээллийн талаарх үнэлгээ бэлтгэнэ. АМГТГ, нүүрсний давхаргын метан хийн салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлнэ.